

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2023.06.29

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Иргэдэд төрийн албаны мэдээлэл, төрийн үйлчилгээ хүргэх багийн өдөрлөгүүдийг 5 багийн төвд зохион байгуулсан.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг төрийн мэдээллийн үйлчилгээний цахим системд байршуулсан.

Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны эхний хагас жилийн тайланг Хууль эрх зүйн хэлтэст явуулсан.

Бага насны хүүхэд зам тээврийн осолд орохоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ГХУСАЗ-н салбар зөвлөл, цагдаагийн хэсэг, багийн дарга нар хамтран сумын төв, хөдөөгийн багуудад ажиллаж зурагт хуудас тараах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зөвлөмжийг хүргэсэн. Энэ чиглэлээр хийсэн ажлын мэдээг өдөр бүр аймгийн Цагдаагийн хэлтэст өгдөг.

ГХУСАЗ-н салбар зөвлөл, цагдаагийн хэсэг санаачлан “Архичид аминчлахуй” ТББ-тай хамтран сургалтын арга хэмжээг зохион байгуулж, төрийн албан хаагчид, архины хамааралтай иргэдийг хамруулж, цаашид суманд “АА” ТББ байгуулах бодлого, зорилтыг танилцуулсан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Сумын уурын зуухны шинэчлэлийн ажлын тендерийг зарлаж/300.000.000/ төгрөгийн өртөгтэй гүйцэтгэгчийг шалгаруулсан.

Элсэлтийн ерөнхий шалгалтад 2 сурагч 700-аас дээш оноотой шалгагдаж, аймгийн хэмжээнд монгол хэл, англи хэлний хичээлээр 1, 3 дугаарт жагссан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Сумын хэмжээнд “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалт, Аймгийн засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны 03 тоот албан даалгаварын хэрэгжилтийг ханган сумын хэмжээнд цаг агаарын гамшигт нэрвэгдсэн малын сэг зэм устгах ажлыг 05 дугаар сарын 28–наас 06 дугаар сарын 09-ний өдрүүдэд удирдан зохион байгуулж, 9 цэгт адуу, үхэр, хонь, ямааны 15550 сэг зэм устгаж, 61600мкв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Орон нутагтаа малчдын залгамж халааг бэлтгэх, шинэ залуу малчдыг дэмжин урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлэх “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ы хүрээнд “Малчдын чуулга, уулзалт”-ыг зохион байгуусан./200 малчин хамрагдсан/ Чуулганд МУСГЗ, цаг уурч н.Шагдарсүрэн, МУ-ын тэргүүлэх мал зүйч, доктор, пр Г.Энх-Манлай, ХХААХҮЯ-ны мэргэжилтэн, ХААИС-ийн доктор пр багш нар, аймгийн ХХААГ, МЭГ-ын мэргэжилтнүүд, “Арга түшиг”, “Малчдад туслах нийгэмлэг” ТББ-уудтай хамтран зохион байгуулав.

Смуын төвд Хавиргын булгийн хөлд “Хиймэл нуур” байгуулах ажлын тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулсан./53.000.000 төгрөгийн төсөвтэй/

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ